80403 - Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас		57,024,600.00	57,024,600.00	55,313,900.00	55,313,900.00
12	Татварын бус орлого	57,024,600.00	57,024,600.00	55,313,900.00	55,313,900.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	57,024,600.00	57,024,600.00	55,313,900.00	55,313,900.00
122005	Төсвөөс санхүүжих	57,024,600.00	57,024,600.00	55,313,900.00	55,313,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,024,600.00	57,024,600.00	55,313,900.00	55,313,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,024,600.00	57,024,600.00	55,313,900.00	55,313,900.00

Арвайхээр сумын ЗДТГ азрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

212	ТАТААС	57,024,600.00	57,024,600.00	55,313,900.00	55,313,900.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	57,024,600.00	57,024,600.00	55,313,900.00	55,313,900.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	57,024,600.00	57,024,600.00	55,313,900.00	55,313,900.00
80508 - Төрийн бус байгууллагад төсвөөс олгох дэмжлэг		46,080,000.00	46,080,000.00	20,480,000.00	20,480,000.00
12	Татварын бус орлого	46,080,000.00	46,080,000.00	5,480,000.00	20,480,000.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	46,080,000.00	46,080,000.00	5,480,000.00	20,480,000.00
122005	Төсвөөс санхүүжих	46,080,000.00	46,080,000.00	5,480,000.00	20,480,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,080,000.00	46,080,000.00	20,480,000.00	20,480,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,080,000.00	46,080,000.00	20,480,000.00	19,110,000.00
212	ТАТААС	46,080,000.00	46,080,000.00	20,480,000.00	19,110,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	46,080,000.00	46,080,000.00	20,480,000.00	19,110,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	46,080,000.00	46,080,000.00	20,480,000.00	19,110,000.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	1,370,000.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	1,370,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			15,000,000.00	-
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого			15,000,000.00	-
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт			15,000,000.00	-
80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		36,000,000.00	36,000,000.00	85,782,800.00	85,782,800.00
12	Татварын бус орлого	36,000,000.00	36,000,000.00	85,782,800.00	85,782,800.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	36,000,000.00	36,000,000.00	85,782,800.00	85,782,800.00
122005	Төсвөөс санхүүжих	36,000,000.00	36,000,000.00	85,782,800.00	85,782,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,000,000.00	36,000,000.00	85,782,800.00	85,782,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,000,000.00	30,564,967.00	85,782,800.00	76,294,852.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,000,000.00	30,564,967.00	85,782,800.00	76,294,852.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,000,000.00	30,564,967.00	85,782,800.00	76,294,852.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	36,000,000.00	30,564,967.00	47,982,800.00	43,977,792.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			37,800,000.00	32,317,060.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,435,033.00	-	9,487,948.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,435,033.00	-	9,487,948.00
81102 - Орон нутгийн нөөц хөрөнгө		112,600,000.00	112,600,000.00	88,350,000.00	88,350,000.00
12	Татварын бус орлого	112,600,000.00	112,600,000.00	56,000,000.00	88,350,000.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	112,600,000.00	112,600,000.00	56,000,000.00	88,350,000.00
122005	Төсвөөс санхүүжих	112,600,000.00	112,600,000.00	56,000,000.00	88,350,000.00

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	112,600,000.00	112,600,000.00	88,350,000.00	88,350,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	112,600,000.00	112,554,307.00	88,350,000.00	86,331,975.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,600,000.00	112,554,307.00	88,350,000.00	86,331,975.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,600,000.00	112,554,307.00	88,350,000.00	86,331,975.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,600,000.00	112,554,307.00	88,350,000.00	86,331,975.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	45,693.00	-	2,018,025.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	45,693.00	-	2,018,025.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			32,350,000.00	-
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого			32,350,000.00	-
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт			32,350,000.00	-
71502 - Хот байгуулалт, тохижилт		1,189,275,600.00	1,189,275,600.00	1,188,918,500.00	1,188,918,500.00
82203 - Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг		140,838,100.00	140,838,100.00	131,763,000.00	131,763,000.00
12	Татварын бус орлого	140,838,100.00	140,838,100.00	131,763,000.00	131,763,000.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	140,838,100.00	140,838,100.00	131,763,000.00	131,763,000.00
122005	Төсвөөс санхүүжих	140,838,100.00	140,838,100.00	131,763,000.00	131,763,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	140,838,100.00	140,838,100.00	131,763,000.00	131,763,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	140,838,100.00	140,838,100.00	131,763,000.00	131,763,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,838,100.00	140,838,100.00	131,763,000.00	131,763,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,838,100.00	140,838,100.00	131,763,000.00	131,763,000.00
210301	Гэрэл, цахилгаан	140,838,100.00	140,838,100.00	131,763,000.00	131,763,000.00
82204 - Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ үйлчилгээ		789,037,500.00	789,037,500.00	805,537,500.00	805,537,500.00
12	Татварын бус орлого	627,037,500.00	627,037,500.00	765,537,500.00	805,537,500.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	583,662,500.00	583,662,500.00	722,162,500.00	762,162,500.00
122005	Төсвөөс санхүүжих	583,662,500.00	583,662,500.00	722,162,500.00	762,162,500.00
123	Татаас санхүүжилтийн орлого	43,375,000.00	43,375,000.00	43,375,000.00	43,375,000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	43,375,000.00	43,375,000.00	43,375,000.00	43,375,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	789,037,500.00	789,037,500.00	805,537,500.00	805,537,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	789,037,500.00	789,037,500.00	805,537,500.00	805,537,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	789,037,500.00	789,037,500.00	805,537,500.00	805,537,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	789,037,500.00	789,037,500.00	805,537,500.00	805,537,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	789,037,500.00	789,037,500.00	805,537,500.00	805,537,500.00

3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	162,000,000.00	162,000,000.00	40,000,000.00	-
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	162,000,000.00	162,000,000.00	40,000,000.00	-
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	162,000,000.00	162,000,000.00	40,000,000.00	-
82207 - Хотын доторх ногоон байгууламжийн үйлчилгээ		259,400,000.00	259,400,000.00	251,618,000.00	251,618,000.00
12	Татварын бус орлого	259,400,000.00	259,400,000.00	251,618,000.00	251,618,000.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	259,400,000.00	259,400,000.00	251,618,000.00	251,618,000.00
122005	Төсвөөс санхүүжих	259,400,000.00	259,400,000.00	251,618,000.00	251,618,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	259,400,000.00	259,400,000.00	251,618,000.00	251,618,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	259,400,000.00	259,400,000.00	251,618,000.00	251,618,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	259,400,000.00	259,400,000.00	251,618,000.00	251,618,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	259,400,000.00	259,400,000.00	251,618,000.00	251,618,000.00
210303	Цэвэр, бохир ус	259,400,000.00	259,400,000.00	251,618,000.00	251,618,000.00
12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	19,200.00	-	19,200.00
16000 - Бусад байгууллага, иргэдээс авах авлагын эцсийн үлдэгдэл		-	124,360,000.00	-	4,409,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		Төгрөгөөр
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	153,239,447.00
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	170,936,059.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	170,936,059.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	170,936,059.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,239,447.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,693,000.00
210401	Бичиг хэрэг	106,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,870,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	716,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,930,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	5,930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	29,373,547.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,373,547.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,242,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,242,900.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,696,612.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,696,612.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	170,936,059.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,936,059.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	33,710,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	14,298,847.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	122,926,612.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ЗДТГазрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Чадварлаг аудит ХХК-ийн аудитор Б.Алтанцэцэг гүйцэтгэж, хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.18-ны өдрийн 03/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Иргэдийн оюунлаг сэтгэлгээ, төрийн оновчтой бодлогод тулгуурлан хүний хөгжлийг дэмжсэн, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээний давуу талдаа түшиглэсэн экологийн тэнцвэртэй хот болно.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Зорилт-1 Орон нутгийн хөгжлийн стратегийн бодлого, төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг хангах

Зорилт-2 Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй, албан хаагчдын шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй байдлыг хангаж, иргэдийн оролцоотой шийдвэр гаргах, тэдний хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээг нэвтрүүлэх, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх

Зорилт-3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, ажилд зуучлах замаар ажлын байрыг бий болгох

Зорилт-4. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлэн, олон тулгуурт эдийн засаг бүхий өрсөлдөх чадвартай аймаг болох

Зорилт-5. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлэх замаар орон нутагтаа тав тухтай ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт-6 Нутгийн захиргааны байгууллагын бүх түвшинд засаглалын хариуцлага, шударга ёсыг мөрдүүлж, цахим технологид тулгуурласан, иргэд тэгш боломж олгодог, оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлнэ.

Зорилт-7 Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын хамрах хүрээг өргөжүүлэн, гэр бүлд ээлтэй жендерийн мэдрэмжтэй цогц бодлого хэрэгжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Сумын Засаг Даргын Тамгын газрын бүтцэд дотоод хяналтын орон тооны алба байхгүй. Сумын Засаг даргын 2018 оны 04 сарын 28-ны өдрийн А/130 тоот захирамжаар Дотоод хяналтын нэгжийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилон байгууллагын дотоод хяналтын журмыг мөрдөн ажилладаг.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ЗДТГазрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 15534.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 233.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 163.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр сумын 12.5 км урттай зам болон 52 айлын орон сууцны гадна талбай, нисэхийн зүүн талын 1 км урттай зам зэрэг хөрөнгийг орлогод бүртгэн 10963.9 сая төгрөг, 160.0 сая төгрөгийн Арвайхээр сумын тохижилтын ажил, Аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 415.0 сая төгрөг, төсөл хөтөлбөрөөр хүнсний ногооны зорь 125.0 сая төгрөг, нийт 11.755.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн. Мөн 2021 онд 8.4 сая төгрөгөөр суурин компьютер, 0.6 сая төгрөгөөр сандал худалдан авсан. Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 2608.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлжээ. Санхүүжилт өмнөх оноос 5.4 хувиар буурсан байна. Энэ ковид-19 өвчний үед төсвийн хэмнэлтийн бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2608.9 сая төгрөгөөр санхүүжигдэн, 2550.6 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Арвайхээр сумын ИТХурлын тэргүүлэгчдийн 2021 оны 08 сарын 26-ны өдрийн 4/09 тоот тогтоолоор тус Засаг Даргын Тамгын газрын төсвийг тодотгон зардлын зүйл анги бүрээр батлахдаа нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэгт 131.7 сая төгрөг, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд 765.5 сая төгрөг, хот доторх ногоон байгууламжид 251.6 сая төгрөг нийт 1148.9 сая төгрөгийг 210801 кодтой бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж гэсэн зардлын зүйлээр баталсан байна.

Засаг Даргын Тамгын Газар нь 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд Арвайхээр Нийтийн тээвэр гэрэлтүүлэгт олгосон санхүүжилт болох 131.7 сая төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГазарт олгосон санхүүжилт 251.6 сая төгрөгийг цэвэр бохир усны зардалд, Арвайхээр Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т олгосон санхүүжилт 805.5 төгрөгийг хог хаягдал зайлуулах зардалд тус тус бичсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант онд 170.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтээр авч мал эмнэлгийн үйлчилгээнд 23.7 сая төгрөг, мал тооллогод 1.4 сая төгрөг, хүн ам орон сууцны тооллого судалгаанд 4.8 сая төгрөг, ковид -19 өвчний тархалтын үед болон цаг үеийн холбогдолтой арга хэмжээнд 123.4 сая төгрөгийг авч зарцуулан 17.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд Конторын сандал 0.6 сая төгрөгөөр худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүйгээс үүдэлтэй гарсан зөрчил юм.

Төсвийн зардлын ангиллыг үл харгалзан санхүүжүүлэлт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана." гэж заасныг хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж байна.

Мөн хөрөнгө зарцуулах, тэтгэмжийн шийдвэрүүдийн хувьд үндэслэл зөрүүтэй, дүрэм, журмыг үндэслэдэг зэрэг дотоод хяналт сул байдалтай холбоотой гарсан зөрчлүүд нь аудитын хувьд гол онцлох асуудал байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Тус байгууллага нь Арвайхээр сумын ИТХурлын тэргүүлэгчдийн 2021 оны 08 сарын 26-ны өдрийн 4/09 тоот тогтоолоор тус Засаг Даргын Тамгын газрын төсвийг тодотгон зардлын зүйл анги бүрээр батлахдаа нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэгт 131.7 сая төгрөг, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд 765.5 сая төгрөг, хот доторх

ногоон байгууламжид 251.6 сая төгрөг нийт 1148.9 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж гэсэн зардлын зүйлээр баталсан байхад, Арвайхээр сумын ЗДТГ газрын 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд Арвайхээр сумын Нийтийн тээврийн гэрэлтүүлэг ОНӨААТҮГазарт олгосон санхүүжилт 131.7 сая төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, Цэцэрлэгжилт ОНӨААТҮГазарт олгосон санхүүжилт 251.6 сая төгрөгийг цэвэр бохир усны зардалд, Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазарт олгосон санхүүжилт 805.5 сая төгрөг, бүгд 1148.9 сая төгрөгийг хог хаягдал зайлуулах зардалд тус тус бичсэн байна.

Дээрх тайлагнасан байдлыг зардлын ангилал зөрүүтэй гэж үзэн залруулга хийлгэхээр асуудлын бүртгэл хүргүүлсэн боловч, залруулах боломжгүй талаар тайлбарыг албан бичгээр ирүүлснийг Дээд шатны байгууллагад нь тайлбарын хамт хүргүүлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд нийт 151 мэдээлэл байршуулахаас 148 мэдээлэл байршуулсан. Шилэн дансны хуулийн 6.4 Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; гэсэн заалтын дагуу тулгалт хийхэд Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нийт 14 удаагийн 1015.6 сая төгрөгийн гүйлгээ, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний дүн бүхий 4 удаагийн 30.6 сая төгрөгийн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант хугацаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжид томоохон өөрчлөлт гараагүй Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтуудад тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу шилэн дансны мэдээллийг бүрэн оруулсан.Нэр бүхий худалдан авсан бараа бүтээгдэхүүнийг аж ахуйн материалын тайланд тусгаагүй зөрчил гаргасныг залруулсан. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх гэсэн зөвлөмжийг биелүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн зардлын зарцуулалтын Хөрөнгө зарцуулах тушаалуудын үндэслэл, тэдгээрийн хүчин төгөлдөр байдалд анхаарах, Шилэн дансны тухай хуулийн заалт бүрийн дагуу мэдээллийг бүрэн байршуулж байх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

4.3 Албан шаардлага

1. Шатахууны зардлын тайланд анхан шатны баримтын бүрдэлгүй жагсаалт, шаардах хуудсаар шатахууныг олгон шууд зардалд тусгасан 8.7 сая төгрөг нь тамгын газрын ажиллагсадаа хаагуур явж ямар ажил гүйцэтгэсэн нь тодорхойгүйгээр жагсаалтаар, шаардах хуудсаар шатахууныг олгосон байна.

2. Санхүүгийн тайлангаар 4.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3. Конторын сандал 0.6 сая төгрөгөөр худалдан авсан.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулаагүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

2021 онд Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нийт 14 удаагийн 1015.6 сая төгрөгийн гүйлгээ, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний дүн бүхий 4 удаагийн 30.6 сая төгрөгийн гүйлгээг байршуулаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хугацаанд байршуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Арвайхээр сумын ЗДТГазар	5	9.3	0	0	0	0	4	9.3	1	1045.6

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.АЛТАНЦЭЦЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 09-НЫ ӨДӨР